БАТЛАВ

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

А. ЭНХМАНЛАЙ

“МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГАЗРЫН НӨӨЦИЙН СУДАЛГАА” АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр №А2/2024-33 Улаанбаатар хот

№	Агуулга	Хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Ажил гүйцэтгэх үндэслэл	- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”; - Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө; - Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 481 дүгээр тогтоол “2024 оныг Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил болгон зарлах тухай”; - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө.
2	Ажлын зорилго, шийдвэрлэх асуудал	Монгол Улсын хэмжээнд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх томоохон төсөл хөтөлбөрүүдийн байршил болон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой газрын нөөцийг Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд туссан эсэхийг тодорхойлох, шинээр төлөвлөж болох газрын нөөцийг судалж тогтоох, төлөвлөлтийн баримт бичигт тусгахад энэхүү судалгааны зорилго оршино.
3	Хамрах хүрээ	Улсын хэмжээнд газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэд ангиллын нийт газар нутаг.
4	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 6 сарын хугацаанд.
5	Ажлын иж бүрдэл	**НЭГ. Судалгааны ажил болон зураглал** **А.Газрын нөөцийн судалгаа болон геологи, хүрээлэн буй орчны суурь судалгаа** - Бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний баримт бичигт тусгагдсан газрын нөөцийн байршлын жагсаалтыг гаргаж, зураглах. (М1:100.000 буюу зохих масштабаар) - Нөөц газар нь ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай (үүнд түгээмэл тархацтай ашигт малтмал болон бичил уурхайн газруудыг хамааруулна), улсын болон орон нутгийн чанартай зам, шугам сүлжээний газар, тусгай

		хамгаалалттай газар нутгийн газар, түүх соёлын дурсгалт газрын байршилтай давхцаж байгаа эсэх судалгааг гаргаж, зураглах. (М1:100.000 буюу зохих масштабаар) - Төлөвлөлтийн баримт бичигт тусгагдаагүй шинээр нөөцөд авах газрын жагсаалтыг засаг захиргааны нэгж болон бүсчлэлээр гаргаж, зураглах. (М1:100.000 буюу зохих масштабаар) **б. Хүрээлэн буй орчны суурь судалгаа** Газрын доройтол: Нөөц газрын доройтлын төлөв байдал, доройтлын хэлбэр, доройтлын эрчмийн зураг, харгалзах тоон мэдээллийг үнэлсэн зураглал. Гадаргын ус /гидрологи/: Гадаргын усны тархалт, нөөц, байршил, ундарга, гол мөрний урсац бүрэлдэх эх, урсацын хурдын мэдээлэл. Хөрс: Хөрсний хэв шинж, бүтэц, тархалтын мэдээлэл. Монгол орны 1:100.000 харьцаатай хөрсний зураглалыг ашиглана. Ургамал: Ургамалжилт, ургамлын аймаг, ургамал зүйн ангиллын мэдээлэл (га-н ургац). Уур амьсгал: Байгаль цаг уур, уур амьсгал, түүний үнэлгээ, төлөв байдал ба өөрчлөлтийн мэдээлэл Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн судалгаанд үндэслэн гамшигт үзэгдлийн давтамж өндөр газрын зураглал үйлдэх. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй цаг агаарын гамшигт үзэгдлийн (ган, цөлжилт, зуд, шороон шуурга гэх мэт) давтамжид дүн шинжилгээ хийж, орон зайн тархалтыг зураглах. Амьтан: Зэрлэг амьтны тархац, байршил, нүүдлийн зүйлүүдийн төллөх болон үржлийн үеийн амьдрах орчны холбоос нутаг, биологийн олон янз байдлын хувьд чухал газар нутаг. Түүх, археологи, өв соёл: Палеонтологи, археологийн олдвор, үл хөдлөх эд өлгийн зүйлс, тэдгээрийн байршил, хамгаалалтын бүсийн мэдээлэл **в. Геологийн суурь судалгаа** Геоморфологи: Газрын гадаргын хэв шинж, налуу, хэрчигдэл, өндөршил, налуугийн чиглэлийн мэдээлэл. Инженер геологийн нөхцөл: Одоо байгаа сум, суурин газруудын суурьшлын бүсүүдийн инженер, геологийн нөхцөлийн судалгаа, мэдээлэл Гүний ус (Гидрогеологи): Уст цэг, инженерийн барилга байгууламж бүхий газруудын ерөнхий зураглалыг харуулах, бэлчээр газар

		тариалан, олборлох үйлдвэр, хүн амын усан хангамжийн нөхцөлийг тодорхойлох. **г. ГЗБГЗЗГ (хуучин нэрээр)-ын даргын 2015 оны А/200 дугаар тушаалаар батлсан тушаалын дагуу дараах тохиромжтой байдлын үнэлгээнүүдийг хийнэ**. Үүнд: - Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ; - Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ (сумын төв, суурин газрын одоогийн тэг гортиг тэлэх боломжит газруудын үнэлгээ); - Шугаман байгууламж байгуулах газрын тохиромжтой байдлын үнэлгээ; - Байгалийн аялал-рекреацийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ; - Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээ. **д. Нийгэм, эдийн засгийн хэрэгцээт байдлын үнэлгээ хийх.** Нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээлэл, түүнд хийсэн дүн шинжилгээг эдийн засаг, үйлдвэрлэлийн салбар бүрээр болон иргэдийн эрэлт хэрэгцээний чиг хандлагыг тогтоох (дотоод, гадаад /SWOT/) болон бусад шинжилгээ хийнэ. Нийгэм, эдийн засгийн хэрэгцээг дараах чиглэлээр тодорхойлж, түүнд шаардагдах газрын хэмжээг тооцоолох: - Нийгмийн дэд бүтцийн хэрэгцээ (сургууль, цэцэрлэг, эмнэлэг гэх мэт төрийн байгууллага, халуун ус гэх мэт үйлчилгээний бусад газар, ногоон байгууламж, цахилгаан, дулаан, цэвэр усны хэрэгцээ); - Шинээр эзэмшүүлэх, өмчлүүлэх газрын хэрэгцээ; - Ажлын байрны хэрэгцээ шаардлага (салбар бүрээр); - Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээ; - Хадлан, малын тэжээлийн ургамлын хэрэгцээ; - Худаг, усан сангийн хэрэгцээ. **ХОЁР. Судалгааны баримт бичиг** Судалгааны баримт бичиг нь энэхүү ажлын даалгаварт тусгагдсан техникийн шаардлагыг хангасан дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд: 1.1. Үндэслэл; 1.2. Зорилго, зорилт; 1.3. Геологи болон хүрээлэн буй орчны судалгаа; 1.4. Газар ашиглалтын тохиромжтой байдлын болон хэрэгцээт байдлын үнэлгээ; 1.5. Нийгэм, эдийн засгийн судалгаан дээр үндэслэсэн газрын эрэлт хэрэгцээний чиг хандлага; 1.6. Төлөвлөлтийн баримт бичигт тусгагдаагүй шинээр нөөцөд авах газрын байршил, хэрэгцээ шаардлага;

		1.7. Улсын хил дагуух аймгуудын хөгжлийн бодлого төлөвлөлттэй тухайн аймгийн хөгжлийг уялдуулан газрын нөөцийг тодорхойлж шийдэл, санал боловсруулах; 1.8. Хот, тосгон, бусад суурины газраас бусад газарт шинээр байгуулах хүнд, хөнгөн үйлдвэрийн схемчилсэн байршил, хэмжээ хил заагийг зураглах; 1.9. Олон улс, улсын чанартай, тусгай зориулалтын авто зам дагуух газарт бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, нийгэм, эдийн засгийн хөгжлийг түшиглэн суурьшлын бүс, амралт, үйлчилгээний бүсийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ ашиглан оновчтой байршлыг тодорхойлох; 1.10. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын бичгээр гаргасан техникийн дүгнэлтийг ажлын явцын болон эцсийн тайлангийн төсөлд тусгаж, эцсийн тайланг хэлэлцүүлж, санал авах; 1.11. Газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэд ангилал хооронд шилжүүлэх газрын байршил, хэмжээ, хил зааг, уг ажлын хүрээнд хийгдэх газар зохион байгуулалтын ажлын төрөл, төсөвт өртгийн тооцоо; 1.12. Төлөвлөлтийн үр дүнд аймгийн хэмжээнд газрын нэгдмэл санд орох өөрчлөлтийг харуулсан Газрын нэгдмэл сангийн ангилалын шилжилт /экспиликац/-ийг гаргах.
6	Гүйцэтгэх ажлын хэмжээ	Улсын хэмжээнд
7	Техникийн шаардлага	- Томоохон хэмжээний төсөл хөтөлбөр хэрэгжих боломжтой газрын нөөцийг шинээр судалж, тогтоохдоо гадны орны туршилгыг судалж, нэвтрүүлэх, шинэлэг шийдлийг санал болгосон байх; - Монгол Улсын Үндсэн хууль, Газрын тухай хууль, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль болон бусад холбогдох хууль, журам, стандартыг баримтлан газрын нөөцийн судалгааг зохион байгуулах. - Газрын нөөцийн судалгааг хийхдээ дараах заавар, дүрэм, стандартыг баримтална. Үүнд: • "Хот байгуулалтын кадастр" /БД 14-102-19/; • "Хот байгуулалтын мэдээллийн сангийн журам" /БХБС-ын 2019 оны 38 дугаар тушаал/; • "Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд барилга байгууламж, тохижилт, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн өгөгдөл оруулах түр заавар" /ГЗБГЗЗГ (хуучин нэрээр)-ын даргын Техникийн шаардлага, заавар 2019 оны А/96 дугаар тушаал/; • "Нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн "Агаарын зураглалын ажлын заавар" /БД 11-113-12/; • "Монгол улсын стандарт Барилга, байгууламжийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт" /MNS6925-6 : 2021/; • "Монгол улсын стандарт Дэд бүтцийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт" /MNS6925-7 : 2021/;

		• "Монгол улсын стандарт Зам тээврийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт" /MNS6925-8 : 2021/; • ГХГЗЗГ-ын даргын 2009 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 224 дугаар тушаалаар батлагдсан "Газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл хөтлөх журам"; • Судалгааны зургийг Монгол улсын стандарт "Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 1:1000, 1:2000, 1:5000 масштабын зургийн таних тэмдэг"; MNS 6316:2012, "Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 1:25000, 1:50000, 1:10000 масштабын зургийн таних тэмдэг" MNS 6317:2012, "Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 1:500000, 1:1000000 Масштабын зургийн таних тэмдэг "MNS 6315:2012 болон атрибут мэдээллийн тоон өгөгдлийн стандарт.
8	Ажлын хяналт, шалгалт	Захиалагчийн техникийн хяналтын зардал нь гэрээний үнийн дүнгийн 5 хувь байна. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар нь газрын нөөцийн судалгаа хийсэн ажлын захиалагчийн техникийн хяналтыг гүйцэтгэх бөгөөд судалгааны ажил нь улс, бүсийн чанартай хөгжлийн бодлого, бүх шатны газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан байдал, судалгааг холбогдох журам, заавар аргачлал, ажлын даалгаврын шаардлагад нийцсэн байдал, судалгааг нэгтгэн тоон хэлбэрээр үүсгэсэн байдалд хяналт хийж, явцын болон эцсийн тайланд мэргэжлийн дүгнэлт гаргана.
9	Ажлын төсөв	130,000,000 /Нэг зуун гучин сая/ төгрөг. Урсгал төсөв
10	Баримтын төвд хүлээлгэн өгөх материал	"Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээний газрын нөөцийн судалгаа"- ны ажлыг дараах байдлаар тайлагнаж, тайлан, баримт бичгийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр бэлтгэн тус бүр 2 хувийг актаар хүлээлгэн өгнө. Үүнд: - Судалгааны ажлын тайлан /Эхний, дунд, эцсийн шатны тайлан/; - Бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт санал тусгах хэрэгцээ шаарлагыг тусгасан зөвлөмж /Бүсчлэл тус бүрээр/; - Монгол улсын хэмжээнд бүх шатны газар зохион байгуулалтын баримт бичигт туссан улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх томоохон төсөл хөтөлбөрүүдийн байршлын судалгааг гаргах, шинээр хэрэгжих боломжтой төсөл хөтөлбөрүүдийн байршлын судалгааг төлөвлөлтийн баримт бичигтэй уялдуулан гаргасан судалгааны баримт бичиг; - Төлөвлөлтийн үр дүнд газрын нэгдмэл санд орох өөрчлөлтийг харуулсан аймгийн хэмжээний нэгдсэн экспиликацийн тайлан. - Газрын нөөцийн судалгааг бүсчилсэн болон засаг захиргааны нэгж тус бүрээр зурагласан зураг /нутаг дэвсгэрийн хэмжээгээр/.

		Тайлан, мэдээллийг хүлээлгэж өгөхдөө ГЗБГЗЗГ (хуучин нэрээр)-ын даргын 2021 оны А/226 дугаар тушаалаар батлагдсан “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн төрийн архивын сан хөмрөгийг бүрдүүлэх, баримт хүлээн авах журам, ГХГЗЗГ (хуучин нэрээр)-ын даргын 2015 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/208 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг үнэлэх, шалгаж хүлээн авах журам", Ерөнхий төлөвлөгөөний тоон зургийн мэдээллийн санг хүлээлгэн өгөхдөө ГЗБГЗЗГ(хуучин нэрээр)-ын даргын 2020 оны А/40 дугаар тушаалаар батлагдсан "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журам"-ыг тус тус баримтална.
11	Захиалагч байгууллага	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар
12	Гүйцэтгэгч байгууллага	Газар зохион байгуулалт, кадастрын чиглэлийн тусгай зевшөөрөлтэй, энэ чиглэлээр ажил гүйцэтгэж байсан туршлага, хүний нөөц бүхий хуулийн этгээд байх.
13	Төрийн нууцыг хадгалах, хамгаалах	Төрийн болон албаны нууцын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад журам, зааврын дагуу төрийн нууцыг хадгалах, хамгаалах ажлыг зохион байгуулна.
14	Даалгаварт тусгагдаагүй ажил	Даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэж болох ба үүнийг гэрээний тусгай нөхцөлөөр тодорхойлно.